

АЛС ХОЛЫН АМЕРИК ОРНОО

(Аян замын тэмдэглэл)

Ж.Болдбаатар (МУИС)

АНУ-д очихсон гэсэн олон жилийн хүсэл мөрөөдөл минь биелж, 2007 оны V сарын 8-наас 20 хүртэл Вашингтон, Филадельфа, Сан-Франциско, Мичиган мужийн Анн Арбор хотод саатах боломж олдлоо. Миний АНУ-д очсон зорилго бол АНУ дахь Монголын Элчин сайдын яамны урилгаар тус улсад байгаа монголчуудтайгаа уулзаж ярилцах, лекц унших Фуртын гэр бүлийн сан, Мичиганы их сургуулиас зохион байгуулах Олон улсын шүүхийн XV бага хуралд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадоржид бараа болон оролцох явдал байв. Бидний Даллесийн нисэх онгоцны буудал дээр элчин сайд Р.Болд угтан авав. Чингээд гол нь түүхчид маань санаа авах болов уу гэсэн хэд хэдэн гол зүйлийг аян замын тэмдэглэлээсээ түүвэрлэн толилуулъя.

Вашингтон хотноо. Надад элчин сайдын өргөөнд буудаллах завшаан тохиолдлоо. Ийнхүү Элчин сайдын гэргий, ажилсаг, эелдэг эзэгтэй М.Оюуны халамжинд багтлаа. Элчин сайд Р.Болд цай уух зуур АНУ-д 20 гаруй мянган монголчууд ажиллаж амьдарч байгаа тухай ярих. Тэд янз бүрийн, гол төлөв хар бор ажил эрхэлдэг. Мэргэжлээрээ ахиж дэвшиж ажиллаж буй цөөн тооны монгол хүн бий гэнэ. Жишээ нь: академич Ш.Бирагийн хүү Аръяа нэгэн том эмнэлгийн тасгийн эрхлэгчийн алба хашиж буй аж. Мөн АНУ-ын Төрийн департаментийн сургалтын төвд доктор Бадан, Наранцэцэг нар багшилж байна. Мөн зарим нэг томоохон пүүс компанид цөөн тооны хүн мэргэжлээрээ ажилладаг юм байна. Бас Индианагийн Их Сургуульд зочин судлаачаар хөгжим судлаач, доктор (Sc.D) Л.Эрдэнэчимэг, доктор (Ph.D) М.Саруул-Эрдэнэ, Л.Цэрэнчунт нар ажиллаж буй.

Р.Болд сайдын “үүрэг болгосон”-оор Наранцэцэг багш намайг Вашингтон хотын байдалтай товч танилцуулж, орой нь нөхөр доктор М.Саруул-Эрдэнэтэй хамт надад зоог барих явцад бид нэлээд зүйлийг ярилцаж амжлаа. Бидний яриа цэвэр эрдэм номын чиглэлтэй байв.

М.Саруул-Эрдэнэ МУБИС-ийн Монгол судлалын сургуульд багшилж байгаад 2002 онд Индианагийн их сургуульд зочин судлаачаар иржээ. Энэ хугацаанд Алтайн хэл шинжлэлээр дагнасан судалгаа хийж, Америк дахь Монгол судлалыг сурталчилах, Америкт Монгол улсыг таниулах талаар их зүйл хийж

байна. Тэрбээр монголчуудын холбоо байгуулан, сонин гаргаж, монголын зохиолч, яруу найрагчдын бүтээлийг англи хэлнээ орчуулан, "Индианагийн их сургуулийн монгол судлаачид" хэмээх ном хэвлүүлсэн байна. Энэ номноос Та Францыг чөлөөлөхөөр дэлхийн II дайнд тулалдаж явсан алдарт эрдэмтэн Дэнис Синьор гуайн Ю.Цэдэнбал даргатай буу халж суусан тухай, монгол, түрэг хэл болон хэл шинжлэлийг эн тэнцүү судалсан нэрт монголч Жон Крюгерийн хэрхэн тод зсгийн дурсгалуудыг "утасны нэг үзүүрээс сонсож байгаа мэт" мэдэрдэг болсон талаар, арван таван хэлэнд нэвтэрхий хар Дорж багшийн хөөмийг анх сонсоод аман дахь зэмсэгийг нь үзэх гэж сонирхож байсан тухай, нөлөө бүхий түүхч Кристофер Этвүдийн Чингис хааныг монгол, түрэг хоёр хэлээр ярьдаг байсныг хэрхэн баталсан тухай уншихаас гадна бусад олон сонин баримт, мэдээ, судалгааны үр дүн, үзэл бодолтой танилцаж болно.

Энэхүү тэмдэглэлээ гол нь түүхчид, түүх сонирхогчдод зориулж байгаа учраас ганц, нэг жишээ татъя. Монгол судлаач Уиллиам Розички (Willian Rosicky) "Манжууд хятадаас бус монголоос үг аваад байсан нь их сонин" гэсэн ярилцлагадаа: "Монголоосоо Манжид орсон болон хоёр хэлний дундын 1381 үг миний толинд бий. Толь гарснаас хойш бүртгэсэн, мөн хүмүүсийн надад хэлж өгсөн өөр олон үг бий" гэж тэмдэглэжээ.

Кристофер Этвүд ярилцлагадаа Чингис хааныг түрэг хэлтэй байсныг нотлохдоо: Жувейнигийн "History of World Congueror" номын 225 дахь талаас эш татжээ. Тэнд: "Нэг хүн Өгөөдэй хаанд "Би таны эцэгтэй зүүдэндээ ярьлаа. Хаан аав чинь миний хүү лалын шашинтнуудыг алах хэрэгтэй, учир нь их муу санаатай улс гэлээ" гэж. Өгөөдэй тэр хүнээс "Та хэлмэрчтэй ярив уу, шууд харилцав уу?" гэж асууж. "Шууд ярьлаа", "Та монгол эсхүл түрэг хэл мэдэх үү?", "Мэдэхгүй", "Миний аав зөвхөн монгол хэд мэддэг байсан юм. Тэгвэл худал" гээд тэр хүнийг цаазаар авчээ. Энэ мэдээний сүүлд зөвхөн монголоор ярьдаг гэсэн боловч анх асуухдаа монгол эсхүл түрэг хэл мэдэх үү? гэсэн нь Чингис хааныг бас түрэг хэлтэй байсныг үзүүлж байгаа юм гэж Этвүд үзжээ.

Вашингтонд дэлхий дахины анхаарлын цэг-Цагаан ордон, Ерөнхийлөгч Вашингтоны өндөр сүрлэг гэрэлт хөшөө, Конгрессийн номын өргөө (номын сан) зэрэгтэй зурвас танилцсан боловч тус хотын төрх, өнгө үзэмжийг мэдэрч, нүд баясаж, сэтгэл бадарч явлаа.

V сарын 19-ний өдөр АНУ-д байгаа монголчууд өөрсдийнхөө хүрээнд анх удаа Монгол судлалын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулжээ. Эл хуралд Монголын түүх, соёл, хэлний талаар олон сонирхолтой илтгэл хэлэлцсэний дотор доктор (Sc.D) Л.Эрдэнэчимэгийн “Өвгөн шувуу” хэмээх дууны гүн ухааны өгүүлэмжийн тухай”, Л.Цэрэнчунтын “Чингис хааны нэрийн тухай” зэрэг илтгэл олны анхаарлыг илүү татаж байсан тухай Элчин сайдын яаманд болсон оройн зоог дээр хүмүүс ярилцаж байв. Харамсалтай нь би энэ хуралд оролцож чадаагүй, Мичиганы их сургуульд болсон хуралтай давхардсан болой. Харин Элчин сайдын өргөөнд болсон зоогонд хуралд оролцогсод ирсэн тул бага сага мэдээлэлтэй болсон юм.

Сан-Франциско хотноо. Вашингтон хотын Даллесийн нисэх онгоцны буудлаас таван цаг гаруй нисч, Лос-Анжелосод буув. Тэнд гурван цаг хүлээгээд жижиг онгоцонд сууж, Сан-Францискогийн дагуул хот Оакландад буув. Намайг Бэй Аэриагийн Монголчуудын холбооны тэргүүн Д.Лувсанжамбаа хэмээх залуу угтаж авав.

Сайхь залуу өмнө Монголын Гадаад хэргийн яаманд ажиллаж байсан өндөр боловсролтой, ёс төртэй нэгэн аж. Намайг Сан-Франциско хотын яг төвд байрладаг HANDLCRY Hotels хэмээх буурчийн газар буулгав. Үдээс хойш Холбооны дэд тэргүүн Ш.Баатар ирж уулзлаа. Лувсанжамбаа, холбооны гол идэвхтнүүдийн нэг Цэрэндорж нар хотын ерөнхий байдалтай танилцуулан, алдарт улаан гүүрийг үзүүлэв. Гүүрний хажуу талын өндөрлөг дээр гарч, далай руу хараа сунгалаа. Байгаль эхийн урлал болох далайн үзэсгэлэн, хүмүүний ур ухааны бүтээл-улаан гүүр хослон нийлээд нэн гайхамшиг. Улаан гүүрийг нэгэн еврей инженерийн төслөөр 1937 он гэхэд барьж дуусчээ. Тэр урт гүүр дундаа ганц тулгууртай. Төмөр олсны татлагын тэнцвэрийг олсон тооцоон дээр л энэ олон жил оршин тогтнож, дагуул хот-Оакланд болон бусад хотуудыг холбодог аж. Хүний оюун ухаан гэж аугаа юм даа.

Бид Берклийн их сургуулиар орж, эртний монгол, төвд номын фондтой товч танилцав. Бараг ихэнх нь төвд ном. Чухам хэдийд, хэн энэ их монгол, төвдийн эрдэнэсийн санг бий болгосон юм бүү мэд. Энэ тухай асуухад түүнийг хариуцдаг өвгөжөөр хүн үл мэдэх аж. Одоогоор Берклийн их сургуульд монгол судлаач алга. Гэсэн ч соёлтой газар сайхан юм. Уг номуудыг нэгэн өрөөнд тусгайлан, нягт нямбай хадгалж байна. Судлаачаа хүлээсээр...

V сарын 12-ны өглөө Ш.Баатар машинтай ирж, Стенфордын их сургуулийг үзүүлэхээр авч явав.

Ш.Баатар ЗХУ, Японд суралцаж, компьютерийн чиглэлээр мэргэшсэн, Арлын оронд амьдарч байгаад, АНУ-д ирж нэлээд хэдэн жилийн нүүр үзсэн. Одоо нэг томоохон компанид мэргэжлээрээ ажилладаг. Орос, англи, япон, хятад хэлтэй, эх түүх, хэл соёлоо эрхэмлэн судалдаг залуу юм байна. Ялангуяа бүддийн гүн ухаан, шашны түүх их сонирхдог. Бэй Аэриагийн монголчуудын холбоог үндэслэж, тэргүүнээр нь хэдэн жил ажиллаад, Далай ламын нэр хүндтэй байгууллагын удирдах зөвлөлд сонгогдсон тул Д.Лувсанжамбаад ажлаа хүлээлгэн өгчээ. Гэхдээ тэрбээр холбооныхоо ажилд тогтмол оролцож, дэд тэргүүнээр ажиллаж байна. Ш.Баатар үнэхээр Монголоо гэсэн чин сэтгэлтэй залуу юм. Жинхэнэ үндсэрхэх үзэлтэн гэж ч хэлмээр... Энэ залуу 3000 орчим номтой. Номын сандаа Монголын тухай англи хэлээр гарсан 800 гаруй ном, бүтээл цуглуулжээ. Сан-Франциско Монголын түүхийн талаар судалгаа хийхээр очсон хүн Баатарын номын санд суухад л өнгөрсөн ба одоогийн дэлхий дахинд түгсэн монгол судлалын номыг бараглаж үзэж болохоор юм байна. Бас орос, хятад, япон хэлээр Монголын талаар гарсан номыг ч чамгүй цуглуулжээ.

Баатарт бас Монголын түүх, соёлын ховор нандин сонин зүйл хадгалагдаж байдаг аж. Тухайлбал, Улаанбаатар хотод гэрийг нь сахиж суугаа ээжид нь II Далай ламын гавлын ясаар сийлсэн бурхан бий гэнэ. Уг бурхныг 1686 онд Абатай сайн ханыг III Далай ламд бараалхахад Халхад шарын шашин дэлгэрүүлэх үйлсэд томоохон хувь нэмэр оруулсан гэж их ламтан түүнд дурсган хадгалуулжээ. Энэ бурхан Баатарт үе уламжлан ирсний учир бол ээж нь Сайн ноён хан Намнансүрэнгийн удмын хүн юм байна.

Баатар бид хоёр бараг хоёр цаг шахам явж, Стенфордын их сургууль дээр ирэв. Энэ сургууль дэлхийн шилдэг арван сургуулийн нэг. Их сургуулийн хотхон хааш хаашаа 5 км-ийн тойрогт оршдог. Эн тэргүүнд, нэг салбар сургуулийн номын санд орж, Монголоос ирсэн, танай номын санг үзэх хүсэлтэй байгаагаа хэллээ. Бид хоёрын бичиг баримтыг үзээд компьютерт оруулж, тэр даруй түр үнэмлэх олгов. Номын санчид нь эелдэг, найрсаг, хүний төлөө гэсэн сэтгэлтэй хүмүүс. Тус номын санд профессор, докторант, оюутнуудын ажиллах бүх бололцоог хангажээ. Докторантууд тусгай өрөө захиалан, уншиж, бясалгах бололцоотой. Уг өрөө орчин

үеийн техникээр тоноглогдсон, дуу шуугиан тусгаарлагчтай юм байна. Үүнтэй харьцуулахад манай номын сангууд бараг л "ном хадгалах агуулах" ажээ.

АНУ-ын Ерөнхийлөгч агсан, нэрт эрдэмтэн Хүүвэр энэ сургуулийг төгсчээ. Түүнд зориулсан цамхаг-музейтэй аж. Цамхаг дээр гарахад их сургуулийн орчин тойрон алган дээр тавьсан юм шиг харагдаж байлаа. Тус сургуулийн нэг жилийн төлбөр 60 мянган доллар. Нийт оюутны гуравны нэг нь хятадууд гэнэ. Хятад улс улам баян чинээлэг, хүчирхэг болж байгаагийн ганцхан жишээ. Бид хоёр улс Монголоо яаж ийм зиндаанд хүргэх вэ? гэж ярьж, санааширч явлаа.

Стенфордоос буцах замдаа Баатарын танил Бат хэмээх монгол хүнтэй уулзав. Энэ хүн Өвөр Монголын Дэ вангийн (Дэмчигдонров) шадар туслах Хасбуугийн Цэрэндоржийн хүү. Харамсалтай нь, сайхь хүмүүн 1950-иад онд Дэ вангийн хамт Монголд очоод буцаж чадалгүй цаазлуулжээ. Бат ойр зуур монгол хэлтэй, алт, мөнгөний дэлгүүр, дархны газар, гуанзтай хөөрхөн чинээлэг амьдралтай, хятад эхнэртэй, хоёр хүүхэдтэй хүн юм байна. Тэрбээр монголоо гэсэн сэтгэлтэй, Бэй Аэриагийн монголчуудыг зун наадам хийхэд тогтмол мөнгөн хандив өргөдөг гэнэ.

Үдээс хойш намайг Оакландад байдаг Ажаа гэгээнтний өргөөнд аваачив. Ажаа гэгээн гэж хэн бэ? гэвэл 1990-ээд онд Монгол оронд бурхны шашныг сэргээхэд хувь нэмэр оруулсан Дээд Монголын эрдэмтэй лам. Ажаа гэгээн Күм бүм хийдэд арван монгол бандийг хүлээн авч, дөрвөн жил бурхны номонд гэгээрүүлсэн хүн. Америкийн Баруун эргийн монголчуудад ямагт номын буян үйлдэж, чин сэтгэлээсээ туслаж байдаг буянтан.

• Ажаа гэгээнтний өргөөнд Монголчуудын холбоо бүхий л ажлаа явуулдаг юм байна. Эл өргөөний түрээсийг Бэй Аэриагийн монголчуудын холбоо даадаг. Уг өргөөнд бурхан тахил, ном тэргүүтнийг залжээ. Энд гуч шахам монголчууд цугласан байв. Энэ өдөр Ажаа гэгээнтний өргөөний хажуу талын өрөөг түрээслэн Монголчуудын холбооны албан байр нээх ёслол болов. Дотроо хоёр өрөөтэй, нэгэнд нь хэвлэл, мэдээлэл хариуцдаг Цэрэндорж тоног төхөөрөмжөө байрлуулжээ. Би "Монголын түүхийн судалгааны өнөөгийн байдал, цаашдын төлөв" хэмээх лекц уншиж, тэдний асуултад хариулав. Үнэхээр улс Монголоо гэсэн залуус энд цугларан иржээ. Тэнд миний шавь нараас ч байв. Би энд МУБИС-ийн түүхийн тэнхмийн багш байсан Эрдэнэбаяртай уулзлаа. Эрдэнэбаяр Холбооны ажилд идэвхтэй оролцдог, англи хэл шамдан сурч байгаа, сайн суурьшаад эрдэм

номоо шамдан үзэх бодолтой байгаагаа ярив. Бэй Аэриагийн Монголчуудын холбооныхон Элчин сайд Р.Болд бидний ажлыг ямагт дэмжиж, туслаж байдаг хэмээн ам сайтай байв. Оройтсон хэдий ч Ш.Баатар, Эрдэнэбаяр бид гурав номын дэлгүүрээр орж, номын богцондоо багагүй олзтой буудалдаа ирэв.

Баруун эрэгт 4 мянга орчим монгол хүн ажиллаж амьдардаг Ш.Баатар, Д.Лувсанжамбаа, Цэрэндорж, Эрдэнэбаяр нар шиг ийм залуус олон байдагсан бол Монголдоо их тус нэмэр болно доо хэмээн бодогдож байлаа. Гэтэл зарим нэг монголчууд нь “Монгол руу дахин хэзээ ч очихгүй, ад зэтгэрийн муухай газар” гэж ярьж явдаг гэнэ. Тийм хүмүүст “Монголоо алдмар” гэхээс өөр юу ч гэж хэлэх юм билээ. “Умгар ч гэсэн хар гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь” хэмээх зүрхэнд шивнэсэн үг байдаг даа. Баруун эрэгт ажиллах ёстой хоёр өдөр дороо л өнгөрлөө. Сэвшээ салхи сэржигнэсэн сэрүүн сайхан Сан-Франциско минь, баяртай.

Филадельфия хотноо түр саатсан минь. Элчин сайд Р.Болд бид хоёр Пенсильваний их сургуулиас зохион байгуулж буй монгол судлаачдын симпозиумын сүүлчийн өдрийн үйл ажиллагаанд оролцохоор Филадельфия хотыг зорив. Элчин сайд замдаа хотын төвд байдаг Элчин сайдын яамаар дайрч, бичиг баримт авлаа. Шаг хийсэн тохилог байртай юм байна. Энэ дашрамд тэмдэглэхэд, Элчин сайдын яамныхан тун их ажилтай, завгүй байдгийг мэдэрлээ. Би Элчин сайдын өргөөнд байрласан хэдий ч Р.Болд сайдтай шөнө дөл болсон хойно л хэдэн үг солих боломж гарч байсан юм. Мянганы сорилтын сантай холбоотой асуудал, Ерөнхийлөгчийн айлчлалын бэлтгэл, Америк дахь 20 гаруй мянган монголчуудын эрх ашиг гээд эх толгойгүй их ажил ундарна. Сайд маань ажилсаг шаргуу, нягт хичээнгүй, өргөн мэдлэгтэй тулдаа л тэр бүхнийг амжуулдаг байх. Элчин сайдын яам тав, зургаахан ажилтантай. Харин зөвлөх Одонжил гээд чадварлаг, шижгэр залуу ажилтнуудтай юм. Зэрвэс танилцахад Элчин сайдын яамны орон тоог ганц, хоёроор ч болов нэмэх, Баруун эрэгт Консулын газар нээмээр юм шиг санагдлаа.

Бид Элчин сайдын яамнаасаа хөдөлж, хурдны замаар гурван цаг шахам давхисаар Пенсильваны их сургууль дээр ирэв. Биднийг Пенсильваны их сургуулийн Археологи, антропологиин музейн Азийн тасгийн судлаач, доктор Paula L.W.Sabloft хүлээн авлаа.

Хурлын төгсгөлийн хэсгийг олон нийтэд зориулан зохион байгуулсан байна. Хуралд Кембрижийн их сургуулиас Дэвид Снийс, Японоос Наками, Индианагийн их

сургуулиас Кристофер Этвүд зэрэг хуучин танил нэрт монголч эрдэмтэд иржээ. Бид халуун дотноор уулзав. Манайхаас энэ хуралд доктор Ж.Энхсайхан оролцсон байна. Кристофор Этвүд монголын гэрийн зохион байгуулалт, ахуй нөхцөл, Дэвид Снийс монгол малчдын төрх төлөв, Ж.Энхсайхан Монгол улсын гадаад бодлогын талаар ярьж, элчин сайд Р.Болдын хамт хүмүүсийн асуултад дэлгэрэнгүй хариулт өглөө

Би энд Пенсильваний их сургууль гэхээсээ АНУ-ын Монгол судлалын гол төв-Индианагийн сургуулийн тухай энэ хуралд оролцож буй тус сургуулийн эрдэмтдээс сонирхлоо. Кристофер Этвүд болон зарим эрдэмтэдтэй зурвасхан ярилцахад Индианагийн их сургууль 1820 онд байгуулагдсан, нийт 8 хотхонд нь 100 гаруй мянган оюутан суралцдаг юм байна. Хамгийн том нь 40 мянга гаруй оюутантай Блүүмингтон хот. Тус хотод Монгол судлалын төв, "Монгол нийгэмлэг" байрладаг. 1967 оноос хойш Монгол хэл, монгол бичиг тасралтгүй зааж иржээ. "Монгол нийгэмлэг" 1961 онд байгуулагдсан, "Mongolian Studies" сэтгүүлийг тогтмол гаргадаг. Энэ нийгэмлэг гишүүнчлэлтэй. Эдүгээ 500 шахам гишүүнтэй. Ашгийн бус байгууллага учраас гишүүдийнхээ татвар, хандиваар санхүүждэг. Тиймээс монгол судлалыг дэмждэг хэн бүхэн гишүүн болох эрхтэй юм байна.

Нийгэмлэгийн Ерөнхийлөгчөөр профессор Хенри Шварц гуай олон жил ажиллажээ. Шварц гуай өндөр настай болсон учир энэ оноос Алисиа Кампид халаагаа шилжүүлсэн байна.

Пенсильваны их сургуулийн зохион байгуулсан хурлын төгсгөлд оролцсон минь завшаантай хэрэг болов. Хэд хэдэн эрдэмтэдтэй уулзаж, ярилцан цаашид хамтран ажиллах чиглэлээ тогтоолоо.

Анн-Арборт. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, доктор Ж.Бямбадорж бид хоёр гол ажлаа нугалахаар Мичиган муж руу нисэв. Детройтийн нисэх онгоцны буудалд газардаад, Анн-Арбор хот руу таксигаар явлаа. Бид хоёрт такси авахад араб болов уу гэмээр өвгөжөөр жолооч таарав. Хаяг, гудамжны зургаа өгсөн боловч, жолооч маань нэлээд будилж байж, очих газраа хүрлээ. Мичиган мужийн төв Анн-Арбор харьцангуй жижигхэн хот аж. Маргааш өглөө нь Олон улсын түүхийн XV бага хурал эхлэх Мичиганы их сургуулийн Хуулийн сургуулийн танхимд хүрэлцэн очив. Хурлын дарга, энэхүү бага хурлыг анх санаачлан зохион байгуулагч, ивээн тэтгэгч Frederick P.Furth эрт иржээ. Бид халуун дотно тэврэлдэн мэндлэв. Миний хувьд өмнө нь Румыний Бухарест хотноо

болсон хуралд оролцож, энэ эрхэм хүнтэй танилцсан болой. Бямбадорж дарга бид хоёр ноён Фуртэд “Говь”-ийн ноолууран, шар өнгийн ороолт бэлэглэсэн юм. Тэрбээр хурал дуустал тэр ороолтыг хүзүүн дээрээ тохож байлаа. Бодвол таалагдсан юм байлгүй. Тэр том, дэлхийн хэмжээний баян хүнд ноолууран ороолт таалагдана гэдэг чинь монголын зарим бүтээгдэхүүн олон улсад брэнд болж байна л гэсэн үг.

Ноён Фурт өмнөх хурлуудад эхнэр юм уу, охиноо дагуулж ирдэгсэн. Энэ удаа аварга том “Дог” нохойтойгоо иржээ. Нохой нь хуралд ч, зоог барих үед ч салахгүй дагана. Хүн гэдэг амьтан аль сонин сонин юм үзэхийг тэр гэхэв. Гэхдээ нохой олон улсын хуралд “оролцох”-ыг анх удаа үзлээ.

Хуралд тавьсан илтгэл, ярилцлагуудад улс орон бүр өөр өөрийн шүүхийн практик, тулгамдаж буй зорилт, харьцуулсан эрх зүйн асуудлуудыг хөндөж байсан. Монгол улсын Үндсэн хуулийн цэцийг төлөөлж Ж.Бямбадорж дарга үг хэлэв. Хуралдааны төгсгөлд Фурт гуай хурлыг үр дүнг дүгнээд, Монгол улс 15 удаагийн хурлаас сүүлчийн аравт нь тогтмол оролцож ирснийг тэмдэглээд, манай оронд очиж байснаа дурсаж, хуралд оролцогсдыг Монголын сайхан оронд заавал зочлон очихыг уриаллаа. Мөн төгсгөлийн хуралдаанд үг хэлсэн хэд хэдэн хүн ардчилсан Монгол улсын талаар өндөр сэтгэгдэл байгаагаа илэрхийлсэн юм. Ийнхүү монголчууд бид дэлхий, дахиныг, дэлхий дахин Монголыг нээж, өөр нүдээр харж эхэлж байна. Хурлын төгсгөлд үг хэлсэн цөөхөн хүний тал хувь нь шахуу Монголыг дурсана гэдэг бид дэлхий дахины анхаарлын төвд байна гэсэн үг ээ. Энэ хуралд 40 шахам улс оролцсон гэж бодоод үз л дээ.

Америк дахь монголчуудын хэвлэл, мэдээллийн сониноос. Энд амьдарч буй монголчууд “Даяар Монгол” (Америкийн монголчуудын хэвлэл), мөн Бэй Аэриагийн монголчуудын холбоо “Замдаан” хэмээх сонин, сэтгүүл гаргадаг юм байна. Эдгээр хэвлэлд цагаачдын талаарх АНУ-ын бодлого, байр суурийг сонордуулахын хамт монголын түүх, соёл болон өөрсдийнхөө амьдралд гарч буй шинэ соргог зүйлийг мэдээлдэг аж. Жишээлбэл, “Даяар Монгол” сонины 116, 117 дугаарт Казакийн спорт, аялалын академийн тэргүүн, математикийн ухааны доктор, Петровын шинжлэх ухаан, соёлын академийн гишүүн Хайрат Закирьянов гэгчийн “Чингис хаан монгол биш, казак-найман хүн байсан” ярилцлага нийтлэгджээ. Тэрбээр Монгол улсад очиж, Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд оролцсоноо тэмдэглээд “Хэрхэн хөл хөөрцөг болон бэлтгэж байгааг

харлаа. Зүй нь энэ ёслолын ажиллагаа юуны өмнө Астанд болох ёстой байсан юм. Дараа нь Казань, Анкар, Ташкент, Бишкект гэх мэтчилэн тэмдэглэгдэх ёстой байлаа. Монголын гэж нэрлэгдээд байгаа 1206 онд байгуулагдсан улсын бүрэлдэхүүнд өнөөдөр казакийн ард түмнийг бүрдүүлж байгаа олон овог аймгууд багтаж байсан. Энэ улсыг Казакын ард түмний гарамгай хүү Чингис хаан байгуулж өгсөн юм" гэжээ. Тэр хүн бас археологич, доктор (Sc.D) Д.Баяртай уулзсан болон түүний ярилцлагыг уншсан тухай дурсаад, монголын энэхүү эрдэмтэн: "... Чингис хаан казакуудад ч, монголчуудад ч адилхан хамааралтай гэж хэлсэн байна билээ. Тусгаар тогтносон 15-хан жилийн дотор монголын урьдаа барьдаг эрдэмтэн нь ийм мэдэгдэл хийхэд хүрч байгаа юм, Ертөнцийн донсоллогчийн судсаар казак цус гүйж байсан гэдэг нь хэнд ч тодорхой. Тэгвэл түүний байгуулсан улс Казакийн анхны төрт улс болох юм" гэж тэмдэглэсэн байна. Мөн академич Д.Цэрэнсодномтой уулзаж ярилцсанаа дурсаад "Чингис хаан болон түүний дайчид Долоон мөрний сав газар, өмнөд Казакстаны нутаг дэвсгэр дээр амьдардаг аргын, найман, кипчак, карлук нарын дундуур гарч, улмаар баруун зүг Алшына руу хөдлөхөд тэд бүгдээрээ казакаар ярьж байсан юм шүү гэж хэллээ. Энэ мэдээлэл дээрх монгол эрдэмтний хувьд санаанд оромгүй хүнд цохилт байсан юм. Хирдхийн цочирдсон тэрбээр жаахан сэхээ ороод казакууд бид тэр үед тэдний орхиж гэссэн төрөлх хэлээ өдий болтол хадгалж ирсэнд баяр хүргэж билээ. Монгол эрдэмтний амнаас ийм үг гарна гэдэг том олз шүү" хэмээжээ.

Хайрат Закирьянов гэгч цааш нь: "... XVII зууны хагас гэхэд Монгол тэр чигээрээ Манжийн дарлалд орлоо. Ингэснээр тэнд үлдсэн монгол овгууд уусч үгүй болсон юм. Эндээс орчин үеийн монгол хэлтнүүд үүсэж бий болсон. Үүний баталгаа гэвэл хэлтнүүд үүсэж бий болсон. Үүний баталгаа гэвэл монголын эрдэмтэн Тайчиуд Очир, Бэсүд Сэржээ нарын "Монголчуудын овгийн лавлах" гэдэг номонд одоо 700 гаруй овгууд монголчуудад бий гэжээ. Тэгвэл Чингис хааны үед 60 гаруйхан овог байсан гэдгийг санах хэрэгтэй. Өнөөгийн Халх гэгдэж байгаа монголчууд хэний удам угсаа вэ? гэдгийг мэдэж цөхөх юмгүй. Тэд бидний аугаа их өвөг дээдэстэй ямар ч холбоогүй, харин орчин үеийн түрэг, казак хэлтнүүдийн салбар байж болох юм гэдгийг би зоригтойгоо хэлэх байна" гэж ярьжээ. Эцэст нь тэрбээр: "Хүн төрөлхтөний түүхэнд гарсан алдаа мадаг гэвэл цөөнгүй. Түүний нэг нь чухам энэ мөн. Одоо энэхүү шударга биш явдлыг казакууд бид засаж залруулах нь даруй бидний нэр төрийн хэрэг" гэж мэдэгдсэн байна.

“Замдаан” сэтгүүлд Ш.Баатар англи, монгол зэрэг хэлээр гарсан Монголын түүхийн холбогдолтой бүтээлийн тухай тогтмол мэдээлж буй нь олзуурхууштай. Жишээ нь: 2006 оны 4 дүгээрт Jon Man-ийн “Хубилай хаан: Хятадыг түвшитгэсэн Монгол хаан” (Kublai khan: The Mongol King Who Conduered China) номын тухай мэдээлжээ. Зохиолын ололттой талыг тэмдэглэхийн зэрэгцээ түүний болчимгүй гаргалгааг шүүмжилжээ. Тухайлбал, уг бүтээлд “... Тулуйтай шинэхэн гэрлэсэн Сорхогтани, түүнийг 7 жилийн хугацаагаар дайнд явсан эзгүй хойгуур нь Мөнх, Хубилай, Хүлэг, Арибөх хэмээх дөрвөн хүүхэд төрүүлсэн гэсэн барууны сэтгэхүйтэй, хэт оmtгой, буруу дүгнэлт хийжээ. Тэд бутачийн хүүхдүүд бол, түүнээс хойш гарсан Монголын хаад алтан ургийн биш болж таарах нээ. Монголчуудын соёлыг өнгөц судлаж гаргасан энгийн алдааны нэг нь гэхэд хатдын ботоха (богтог) малгайг модоор хийсэн гэж бичсэн байна. Уг нь үйсээр хийсэн хөнгөн чанарын малгай юм, түүнээс модоор хийсэн гэвэл яаж толгой дээрээ дааж явдаг бол гэж хүн гайхахаар санагдлаа. Энэ мэтээр алдаа мэдгийг нь сайн хэлэлцэж байхгүй бол бид чинь гадны хүний бичсэн болгоныг адислан шүтээд баймааргүй санагдлаа. Хэдийгээр дэл сул алдаа байгаа хэдий ч их хөдөлмөр орж бичсэн, Монголыг баруунд сурталчилсан том хэмжээний бүтээл болжээ” гэж Ш.Баатар бичсэн байна.

Эндээс ургуулан тэмдэглэхэд, монголын эрдэмтэд хэлний саад бэрхшээлээс болж англи болон бусад харь хэлээр гарсан зүйлийг харьцангуй бага ашиглаж, түүнчлэн гаднын монголч эрдэмтэд монгол судлаачдын бичсэн зүйлийг тэр уншин мэдэрдэггүйгээс янз янзын туйлширсан дүгнэлт, гаргалгаа хийхэд хүрдгийг цаашид бодолцох хэрэгтэй юм.

Төгсгөл. “Холын Америк ойртож байна” хэмээх өгүүллийг би 1993 онд билүү бичиж байж билээ. Одоо бодоход тэр үед ойртож байсан хэдий ч бас хол байж, харин өдгөө жинхэнэ ойртжээ. Цаашид улам бүр ойртох нь дамжиггүй. Найрсаг харилцаа, хамтын ажиллагаа маань өгөөжтэй байх ёстой, ялангуяа бидний монголчуудын зүгээс ивээл, өглөгийг үр бүтээлтэй ашиглах ёстой. Сэтгэл хөдлөөд гэх үү, санаа цалгиад гэх үү дараах толгой холбосон мөрүүд (шүлэгэрхүү юм) орж ирлээ.

Арав гаруй жилийн өмнөхөн

Аймшиг, ад зэтгэрийн мэтээр төсөөлж байсан

Алс холын Америкт зочлон ирлээ.

Ардчилал, эрх чөлөөг анхлан амьлуулагч

Аз жаргал, түмэн амгаланг цогцлон бүтээгч
Америкчууд Та бүхэн сайн байна уу
Зүүнээс баруун эрэг хүртэл нисч
Зүйл бүрийн гайхамшиг бүтээснийг нүдээр үзлээ
Эгэл жирийн иргэнээс эхлэн
Эрдэмтэн мэргэдтэй үзэл бодлоо солилцлоо
Тэд бүхний царайд инээмсэглэл тодрон
Тэргүүнээ эрхэмсэг бардам өргөвч
Тив, дэлхийн хэнийг тэгш дүүрэн хүндэлнэ.
Хар, шар, цагаан арьстан хэн ч бай
Харц тулгарсан болгонтойгоо эелдгээр мэндлэнэ
Харийн Америк холын Монголд ч ойртжээ
Хамгаас дотно сэтгэл өвөрлөвч
Халуун элгэн нутаг руу эргэн хурган тэмүүллээ.

Вашингтон- Сан-Франциско- Филадельфа-Анн-Арбор.

2007 оны V сар